

Шинжлэх ухааны хүрээлэнгийн Шашныг судлах болон гүн ухааны тасгийн тухай

Мөнхцэрэнгийн Золзаяа

Доктор (Ph.D), дэд профессор

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс

zolzaya@mas.ac.mn

Хураангуй

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1930 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэрээр Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнг БНМАУ-ын Шинжлэх Ухааны Хүрээлэн болгож өөрчлөн байгуулж, 1957 онд Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэн болгон өргөжсөөр 1961 онд Шинжлэх Ухааны Академи болон зохион байгуулагдсан. Тус өгүүлэлд Судар бичгийн хүрээлэнгийн Шашин мөргөлийн зүйлийг шинжлэх кабинет нь Шашныг судлах тасаг, улмаар Гүн ухааны тасаг болон зохион байгуулагдсан түүхэн баримтыг шинжлэх замаар Шинжлэх ухааны хүрээлэнгийн бүтэц дэх шашин, философийн асуудлыг судлах нэгжийн зохион байгуулалт, эрхэлсэн ажлын тухай өгүүлэх болно.

Түлхүүр үгс: *гүн ухааны судалгаа, марксист философи, шинжлэх ухааны түүх, буддын шашин, шашныг эсэргүүцэхүй*

On the Department of Religious Studies and Philosophy of the Institute of Science

Zolzaya Munkhtseren

Doctor (Ph.D), associate professor

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia

zolzaya@mas.ac.mn

Abstract:

It has been some time since Mongolia planned policies and activities towards ensuring the professionalism of the civil service. However, one of the serious problems in ensuring the professionalism of the civil service is patronage. In the context of the article, the researchers tried to give a clear idea of patronage, and its political approach.

Keywords: *philosophical studies, Marxist philosophy, history of science, Buddhist religion, religious opposition*

<https://orcid.org/0000-0001-6083-1445>



© The Author(s) 2023

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

Received: 29 August 2023

Accepted: 05 October 2023

I. Оршил

Энэ өгүүлэлд Монголд философи, шашин судлалын асуудлыг шинжлэх ухааны үүднээс судлан боловсруулах байгууллагын үндэс суурь тавигдсан түүхийг тодруулахыг зорьж буй болно. ШУА-аас эрхлэн хэвлүүлсэн “Монгол Улсын шинжлэх ухааны түүх” бүтээлийн нэгдүгээр ботид орчин цагийн шинжлэх ухааны байгууллагын үндэс суурь болсон (Ч.Батдорж, Н.Хишиг, С.Чулуун 2021) тухай дурджээ. Мөн бүтээлийн хоёрдугаар ботид 1937 оны үед Шинжлэх ухааны хүрээлэнд Шашин, түвэд судлалын тасаг ажиллаж байсан бөгөөд орон хийдийн жасын эдийн засаг, лам нарын хөрөнгө хогшил, татварын талаарх мэдээллийг Сангийн яам, Дотоод яам, Тоо бүртгэлийн газруудаас хуулбарлах ажлыг тус тасгийн судалгааны гол хэрэглэгдэхүүнд тооцож байжээ (Б.Пунсалдулам, С.Амарбаяр, Ц.Энхжаргал 2021) хэмээжээ. Мөн Гүн ухааны тасгийн талаарх баримт ном бүтээлд төдий л дурдагдаагүй тул зохиогч 2022 онд хэвлэгдсэн “Философийн хүрээлэнгийн хагас зууны түүхэн товчоон” хамтын бүтээлд товч авч үзсэн бөгөөд энэ удаа нэмэлт мэдээллээр баяжуулж зарим тодруулгыг хийв.

II. Судалгааны арга зүй

Тус судалгаанд Үндэсний төв архивд хадгалагдаж буй холбогдох баримтуудыг түүхийн эх сурвалжийг шинжлэх арга зүйг ашиглан холбогдох дурсамж, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны хамтын бүтээлүүдэд тулгуурлан авч үзэв. Эл судалгааны ажил нь Монгол дахь хүмүүнлэгийн ухааны академик байгууллагын түүхэн хөгжлийн судалгаа болон шинжлэх ухаан судлалд хувь нэмэр оруулах ач холбогдолтой гэж үзэж байна.

III. Судалгааны үр дүн:

Судар бичгийн хүрээлэнд Дарба бандида, Ш.Дамдин, Н.Эрдэнэпэл, Наваанцэрэн зэрэг хувилгаан, эрдэмтэн лам хуврагууд буддын шашин, соёлын судалгааны эх хэрэглэгдэхүүнийг эрхлэх, судар ном цуглуулах зэргээр хувь нэмэр оруулсан байна. Мөн Зөвлөлтийн эрдэмтэн М.И.Клягина-Кондратьев, М.И.Тубянский нар бурхны шашны соёл, буддын гүн ухааныг судалж байжээ. М.И.Тубянскийн эцэг Михайл Израйлович нэрт эрдэмтэн буддын судлаач Ф.И.Щербатскийн удирдлагаар санскрит, түвэд хэл, буддын гүн ухаанд суралцсан нэгэн байсан бөгөөд тэрээр 1927-1936 онд Монголын сүм хийдийн материалыг судалж байжээ (АЕГ, 2011). М.И.Тубянский 1927-1936 онд Монголын сүм хийд, буддын гүн ухааныг судалж санскрит хэлний дамжаа хичээллүүлжээ (Ч.Батдорж, Н.Хишиг, С.Чулуун 2021). ЗХУ-ын ШУА-ийн Ленинград хот дахь Буддын соёлын хүрээлэнг 1928 оноос академич Ф.И.Щербатской толгойлж байв. Дараа нь тус хүрээлэн Дорно дахин судлалын хүрээлэнгийн Энэтхэг-Төвөдийн кабинет болон өөрчлөн байгуулагдаж (Ч.Батдорж, Н.Хишиг, С.Чулуун 2021), тус хүрээлэнгийнхэн Монголын буддизмын талаар анхааран судалж байжээ.

Эхний жилүүдэд гүн ухааны судалгаагаар тусгай нэгж ажиллаагүй ч шашин мөргөлийн зүйлийн болон түүх, хэл бичгийн зарим судалгааны хүрээнд буддын гүн ухаан, соёлын асуудал багтаж, улмаар марксизмын талаарх ном бүтээл орчуулах

ажлууд хийгджээ. Тухайлбал, Ж.Цэвээний шавь Судар бичгийн хүрээлэнгийн Европ хэлний орчуулгын албанд ажиллаж байсан Ц.Дамбадоржийн орчуулгаар Ф.Энгельсийн “Өрх гэр, өмч хөрөнгө хийгээд төр, засгийн үүсэл” хэмээх номыг 1928 онд эрхлэн хэвлүүлсэн (Ч.Батдорж, Н.Хишиг, С.Чулуун 2021) аж. Шашин, шүтлэгийн асуудлыг судлах ажил үргэлжилсээр 1930-аад оны сүүлээс төрөөс шашны талаар баримтлах бодлогын зорилтод нийцүүлсэн шинжлэх ухааны үндэстэй сурталчилгааны хэрэглэгдэхүүн бэлтгэхэд ихээхэн анхаарах болсон байна.

Шашныг судлах тасаг: Энэтхэг-Төвөдийн кабинет нь Шашны судлах тасаг нэртэй болжээ. Тус тасгийн ажлын төлөвлөгөө, тайланд Цэвлээ гэсэн гарын үсэгтэй байна. Цэвлээ нь хэл шинжлэлийн салбарын нэрт толь зүйч эрдэмтэн Я.Цэвэл байжээ гэдгийг дараахь хэдэн зүйлээс тод харагдаж буй юм. Я.Цэвэл нь 1938 онд Эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх түр сургуульд багшилж байсан (Ц.Шагдарсүрэн 2020, 8) бөгөөд 1929 онын 10-р сараас Судар бичгийн хүрээлэнд анх орсон ба 1967 онд өөрийн хүсэлтээр тэтгэвэрт суусан ажээ. Мөн тэрээр өөрийн намтарт “1938 онд Эрдэм шинжилгээний ажилтан нарыг бэлтгэх түр сургууль, 1941 онд Улсын Их сургуулийн бэлтгэл анги зэрэгт монгол хэл бичгийн хичээл зааж байсан бөгөөд барагцаалж бодоход 500-аас доошгүй хүнд монгол бичиг заан сургаснаас гадна Шинжлэх ухааны хүрээлэнгийн ажилтан ажилчдад шинэ үсэг зааж сургах ажилд 10-аад жил багшилж олон арван хүнийг сургаж тайлсан болно... (Ц.Шагдарсүрэн 2020) хэмээсэн ч Шашныг судлах тасгийн эрхлэгчээр ажиллаж байсныг дурдаагүй байгаа юм. Харин хүрээлэнд ажилласан хугацаанд ерөнхий хэлтэс, улсын архив, номын сан, дуун ухаан, **гүн ухаан**, хэл бичиг утга зохиол, хэвлэлийн зэрэг хэлтэс, газар, кабинет **тасгийн дарга, эрхлэгч**, судлагч, эрдэм шинжилгээний ажилтнаар үйлдвэрийн төлөвлөгөөг хангаж биелүүлэхийн тулд чармайн зүтгэсээр ирсэн болно хэмээн нэгтгэн өгүүлснээс баримтууд дээрх гарын үсэг Я.Цэвэл агсных гэдэг тодорхой болж байна. Зохиогч түүний хүү эрдэмтэн Ц.Шагдарсүрэн, ач охин доктор Ш.Эгшиг нараар гарын үсгийг таниулсан болно.


1938 онд Шашны явдлыг судлах (зарим баримтад Шашныг судлах тасаг гэжээ) тасгийн дэргэдэх зөвлөгөөнийг байгуулах тухай баримтад дурдсанаар “Шинжлэх ухааны хүрээлэнгийн өргөтгөсөн хоёрдугаар бүгд хурлын илтгэл тогтоолын бодлого, хурал дээр гарсан санал шүүмжлэлийг баримтлан Шашны явдлыг судлах тасаг нь өөрийн ажилд холбогдох газрууд, тасгийн ажилд сонирхолтой үзэгчид ба оюутан идэвхтний хүчийг нэгтгэн холбож, тэдний санал зөвлөгөө, хүч тусламжийг авч ажиллах чухал” (ШУХ. х.23, д.1, хн. 538, 6-7, МУУТА) болохыг зааж мөнхүү зөвлөгөөний хурлыг улирал тутам тогтмол хуралдуулж, урьдчилан хэлэлцэх асуудлыг оролцогчдод тарааж танилцуулж байх, зөвлөгөөний хуралд оролцогчид нь Я.Цэвэл, Симуков, Б.Банзрагч, оюутан Дамдинсүрэн, Дамбийням, Баярсайхан, Казакев, Галиндэв, Самбуу, Намын Төв хорооны дарга, Түүхийн мэргэжилтэн Дүсөв (*энэ нэрийн бичвэр гаргац муутай байв*), Левицкин, Хүн эмнэлгийн Чөнтөмөр, багш Цэвэгмид, Азурга, Туваан нарын 16 хүний бүрэлдэхүүнтэй байхаар тогтжээ.

Тус зөвлөгөөн дээр Шашныг судлах тасгийн эрхлэгч Я.Цэвэл тасгийн зорилго, шашны талаар нам засгаас явуулж буй бодлогод нийцүүлэн тасгаас хийх ажлын төлөвлөгөө, хэвлэн нийтлэх зүйлсийн талаар илтгэл танилцуулга хийжээ.

Зөвлөгөөнд оролцогчдоос хэд хэдэн хүн санал, шүүмж хэлсэн байна. Тухайлбал, Найдан “Нөхөр Цэвэлээс нам засгийн бодлогын ёсоор өөрийн ажлыг эмхэтгэн байгуулж байгаа нь сайшаалтай хэрэг. Үүнд манай улсын ард түмний дунд шашны хуурмаг байдлыг илрүүлэн таниулах явдал шаардагдан байсан хэрэг... шашны сэтгэлийн гүн ухааныг бодисыг баримталсан гүн ухаанаар (материализм М.З.) цохивоос зохимуй.” гээд, тус тасгаас эрхлэн гаргахаар төлөвлөж байсан есөн дэвтрийг яаралтай гаргах нь зүйтэй гэжээ. Оролцогч Содном “Шашинтай тэмцэх бэрхтэй ажил. Ялангуяа буддын гүн ухааныг нарийн шинжлэх хэрэгтэй. Манай шашин хүний сэтгэлд лав орсон учир буддын гүн ухааны тухай бодолцож, гүн ухааныг зориуд цохих хэрэгтэй байна. Гагцхүү шашны тухай зүйлийг гаргах бус, үүний зэрэгцээ жинхэнэ бодисыг баримталсан ёсны элдэв зүйлүүдийг хамт гаргах хэрэгтэй. Одоо өсөж буй жижиг хүүхдүүдийг ч орхиж болохгүй. Энэ талаар тэдэнд тохирох зүйл гаргах хэрэгтэй. Шашныг эсэргүүцэх музейн талаар Чойжин ламын сүм музейд бага зэргийн музей байгуулж, бусад ерөнхий музейг жишээлбэл, Эрдэнэзуу мэт газарт байгуулж болно...” (ШУХ. х.23, д.1, хн. 539, 1-2, МУУТА) зэргээр байр суурь илэрхийлжээ. Мөн оролцогч Туваан “Дээрх нөхдийн гаргаж буй шүүмжлэлийн дотроос түвэд номыг мэддэг шинэ хүчнийг бэлтгэх хэрэгтэй. Шашны ном мэддэг залуу лам нарыг ашиглан хүмүүжүүлэн шинэ хүчин бэлтгэх чухал”, Намдаг “...Би бас нэг гайхах зүйл байна. Бид нам засгийн даалгаврыг биелүүлэхийн тулд шашинтай ямраар ч тэмцэхэд бэлэн боловч зэвсэг болох Маркс, Энгельс, Лениний онол зохиолыг дэлгэрүүлэх явдал дутагдалтай түүнээс гадна Дарвины суртлыг дэлгэрүүлэх чухал. Ер нь өдий төдийгөөр ардыг мөлжиж ирсэн шашныг үндсээр устгахад ихээхэн хүч хэрэгтэй... Үүнээс гадна шашныг судлах тухайн сургуульд хүн явуулж бэлтгэх хэрэгтэй”, Ядамсүрэн “Түвэд хэл дээрх төдий олон ном дэвтрийг судлан боловсруулж байх нь чухал. Одоо хэр түвэд хэл мэдэгчдийн тоо цөөн, иймд эртхэнээс заалгах шинэ хүчнийг сонгон авч түвэд бичиг үсэгт сурган хойчийн өдөр хэрэглэхэд дөхөмтэй болгох нь чухал” гэжээ. Оролцогчид шашныг эсэргүүцэх музей байгуулах талаар санал нэгдсэн ч хаана байгуулах, сүм хийд тохиромжтой эсэх талаар өөрсдийн саналыг хэлжээ.

Харин Зөвлөлтийн элчин яамны ажилчин Левицкин “Шашны гүн номлолыг илрүүлэн судлахын хамт, лам нарын анги ялгаврыг гаргах хэрэгтэй. Ер нь дээд, доод гэсэн хоёр анги буй, энэхүү ялгааг судлах чухал. Лам нарын гүн ухааны ёс суртлыг бут цохин устгах чадал манай Шинжлэхүй ухааны хүрээлэнд бүрэн байна... Нам эвлэлийн сургуульд зориулан Маркс, Ленинээс шашныг тайлбарласан зүйлээс түүвэрлэн тусгай дэвтэр гаргаж нийтлэх нь туйлын чухал” хэмээжээ. Оролцогч Сүндэв “Марксын бодисыг баримталсан суртлыг баримталж шашинтай үзэл суртлыг талаар их тэмцэл явуулах... Зөвлөлтийн эрдэм шинжилгээний ажилтнуудтай харилцаа байгуулж, тусламж дэмжлэг авах зэргээр ажиллах” (ШУХ. х.23, д.1, хн. 539, 1-2, МУУТА) хэрэгтэй зэргээр зөвлөгөөн дээр шашны эрэг тэмцэх арга зам бол марксист ленинист сургаалыг сурталчлах явдал гэдгийг онцолжээ.

Тус тасгаас 1938 оны ажлын төлөвлөгөөнд “Сүм хийдийн газрын зургийг засварлах, нэмэх. Тусгай төлөвлөгөөний дагуу ард лам нарыг мөлжих феодал лам нарыг судлах.



Зураг 1. Шашин, лам нарыг судлах тасгийн 1938 оны ажлын төлөвлөгөө

бүтээх хамтын ажиллагааны үр дүнгээр “Лам нарын эсрэг агуулгатай уран зохиолын бүтээл” нийтлэхээр төлөвлөжээ. Мөн чиг үүргийнхээ хүрээнд БНМАУ-ын түүхэнд холбогдох түвэд материал, Түвэдийн эм зүйн материалыг боловсруулах ажлыг ёс журмын дагуу зохицуулах гэж заасан байна (ШУХ. х.23, д.1, хн. 538, 6-7, МУУТА).

1938 оны ажлын төлөвлөгөөний биелэлтэд тухайн үед нам засгаас лам нар ба шашны талаар тавьж буй зорилгод тусламж болгож хэвлэн нийтлэх зүйлийн төлөвлөгөөг гаргаж, үүнд 1-р дэвтэр нь “Хүн төрөлхтний гарал үүсэл, шашны үүсэл, шалтгаан, бөөгийн шашны тухай, буддын, христосын, лалын, күнзийн шашин, шашин хэмээх ерөнхийдөө юу болох, шашин ба улс төр, шашин ба шинжлэх ухаан, шашныг улс төрөөс тусгаарласан бодлого гэсэн 11 сэдэв боловсруулах”, “Лам нарын эдийн засгийн байдал, ардуудыг мөлжих аргыг илэрхийлэх талаар” гэсэн чиглэлд 1-р дэвтэр нь “Түвэд эмнэлгийн тухай зарим зүйлүүдийг боловсруулан гаргах”, 2-р дэвтэр нь хүрээнд “Лам нараас ардыг мөлжих арга ба лам нар, ард хоёрыг хооронд нь холбодог байдлын тухай баримт хэрэглэгдэхүүнийг боловсруулан зохиож

2 * Ц.Шагдарсүрэн “Ядамжавын Цэвэлийн амьдрал, үйл ажиллагаа (1902-1984)” өгүүлэлд түүний “Хутагт хувилгаадын гарал үүсэл” бүтээл нь тухайн цаг үеийн шалтгаанаар нийтлэгдэж олны хүртээл болж чадаагүй тухай өгүүлжээ.

Буддизмын түүхийн материал цуглуулах ажлыг үргэлжлүүлэх. Төвөдийн анагаах ухааныг судлах материалыг боловсруулах” зорилттой бөгөөд энэ хүрээнд “Шашны үүсэл, түүний түүх, шашин ба төр, шашин ба шинжлэх ухаан”, Судар бичгийн хүрээлэнгийн эх материалууд ба түүхэн эх зохиолоос “Энэтхэг, Төвөд, Монгол дахь буддизмын дэлгэрлийн түүх”, “Монгол дахь ламаизмын үүсэл, түүх” бичих, архивын эх материалаас “Хутагт хувилгаадын түүх”,^{2*} “Төвөдийн анагаах ухааны тухай”, “Лам нарын ардыг мөлжих арга”-ын талаар мэддэг хүмүүсээс холбогдох материалыг тэмдэглэж нийтлэх, “Лам нарын эсрэг аман зохиолын эмхэтгэл”, Дээд шүүхийн материалаас “Лам нарын хувьсгалын эсрэг үйл ажиллагаа”-ны тухай эмхэтгэх, Үндэсний зохиолчид, урлан

гаргах”, 3-р чиглэлд Лам нарын хуурмаг тусгүй байдлыг илэрхийлэн эсэргүүцэх талаар: 1-р дэвтэр “Лам нарын хуурмаг арга мэхлэлийн чанарыг илэрхийлсэн өгүүллүүдийн цуглуулгын нэгтгэл боловсруулж гаргах”, 2-р дэвтэр “Лам нарыг эсэргүүцсэн хувьсгалын уран зохиолын зүйлийг шинээр зохиож гаргах” зэрэг ажлыг төлөвлөжээ (ШУХ. х.23, д.1, хн. 583, 9-16, МУУТА). Эдгээр ажлын зарим нь биелж мөн оны 11 дүгээр сарын 16-нд “Шашин бол хар тамхи мөн” хэмээсэн зохиолын 1-3 дэвтрийг бэлтгэн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлжээ (ШУХ. х.23, д.1, хн. 583, 28, МУУТА). Харин 1938 оны ажлын төлөвлөгөөнд туссан “Монгол орны сүм хийдийн зургийг боловсруулан хянаж дуусгах” гэсэн ажлын хувьд Дотоод яамны Шашны асуудлыг эрхлэх (Улс төрийн бүртгэлийн газрын) хэлтсийн холбогдох хэрэглэгдэхүүнтэй нийлүүлэн хянаж боловсруулах, засвар хийж харьцуулалт бүрэн боловсруулагдаагүй (ШУХ. х.23, д.1, хн. 583, 9-16, МУУТА) гэсэн байна.

Дээрх баримтыг тодотгох баримтыг 1961 оны “Шинжлэх Ухааны Академийн мэдээ” сэтгүүлд ...Тус оронд байсан олон сүм хийдийг аялуулах үе буюу 1939 оны орчим Шинжлэх Ухааны Хүрээлэнгээс олон сүм хийдийн дотроос түүх дурсгал, уран барилгын хувиар чухалд үзвэл зохих Эрдэнэ зуу, Амарбаясгалант, Дамбадаржаа, Манзуширын хийд, Ламын гэгээний хийд, Байвлагийн хийд, Төвхөн хийд, Гүнжийн сүм, Өндөр Жанрайсэгийн сүм, Өндөр Майдарын сүм, Чойжин ламын сүм, Амгаланбаатар хотын Гэсэрийн ба Дарь эхийн сүм, Гандан, Зүүн хүрээний орд, Бор өргөө зэрэг нийт хорь шахам хийд сүмийг улсын хамгаалалд авч, тэдгээрийн түүх дурсгалын ач холбогдол сэлтийг тодорхойлон Засгийн газар, Намын Төв Хороонд албан ёсоор санаалаа тавиад хойноос нь хэд хэдэн удаа шаардсан боловч бүтэмж урагшгүй үгээр мохоож өнгөрүүлснээс гадна, хүрээ хийд сүмийн газруудад байгаа бурхан, ном судар, номын бар, бичиг данс, урлалын янз бүрийн сонин ховор юмс зэрэг соёлын өв болох зүйлийг үрэгдүүлэхгүй улсын хамгаалалд татаж хадгалах тухай саналыг дээд газар дэвшүүлэн тавихын хамт дэргэдээ байсан Улаанбаатар хотын доторх олон сүм орон дацанд байсан соёлын өв хөрөнгө болох зүйлсийг биечлэн явж үзэж ялгаад татаж авахын төлөө хэчнээн хөөцөлдөж тэмцсэн боловч олигтой амжилтад хүрч чадсангүй нь даанч харамсалтай болсон билээ (Я.Цэвэл 1961) гэж тухайн үеийн шашин, соёлын өвийн талаар хийж байсан ажлыг тодорхой бичсэн байна.

Шашны явдлыг судлах тасгийн үйл ажиллагаа нь Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн ба Сайд нарын зөвлөлийн хийгээд хүрээлэнгийн Бүгд хурлаас зааж тогтоосон ёсоор ажиллаж байсан. 1938 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр БНМАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэнгийн Шашны явдлыг судлах тасгийн анхдугаар зөвлөгөөний хуралд тус тасгийн эрхлэгч, Цэвэлийн илтгэлийг сонсоод тус хурлаас долоон заалт бүхий тогтоол гаргажээ. “Үүнд: тус тасаг үйл ажиллагаандаа нам засгаас явуулж буй бодлогод тусгуулах зорилтод чиглэсэн зарим өөрчлөлт хийснийг онцолжээ. Мөн хийх ажлын төлөвлөгөөг баталж хэрхэн биелүүлэхийг тасгийн эрхлэгчид даалгаж, тасгийн гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлууд нь шинэ тутам бөгөөд хялбар бус асуудал тул тус тасгаас дангаар эрхлэн гүйцэтгэхэд хүн үл хүрэлцэнэ. Иймд энэхүү ажлыг гүйцэтгэхдээ зохих мэргэжилтэн ба үндэсний ард сэхээтэн нарын хүчийг дайчлан оролцуулахыг анхаарахаас гадна ялангуяа зөвлөгөөний гишүүдээс тус тус оногдсоныг үүрэг болгосугай” гэсэн байна. Тус

тасгийн хурлын зөвлөгөөний гишүүдэд хэрэглэгдэх материал хэрэглэгдэхүүн ба зохих төрлийн цуглуулгыг олж цуглуулах, бүртгэх, ашиглах талаар зориуд анхаарал тавьж ажиллахыг даалгажээ. Мөн “Тасгийн хэвлэн нийтлэх зүйл болбоос ерөөс зарим хэвлэл лүгээ адилтган үзэж үл болох бөгөөд улс төрийн талаар сайтар боловсруулан хянаж гаргах явдал чухал тул тус зөвлөгөөний хурлаас мөнхүү хэвлэх зүйлийг хянах хариуцлагатай оролцоотой хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Банзрагч, Намын Төв хорооны суртлын эрхлэгч Лувсанбазар, Эвлэлийн Төв хорооны орлогч дарга Самбуу, Дотоод Яамны Шашны газрыг эрхлэх хэлтсийн Баярсайхан, Тасгийн эрхлэгч Цэвэл нарыг оролцуулсугай” хэмээн онцлон заажээ. Тус тасгаас шашныг эсэргүүцэх тухай үзэсгэлэн байгуулахыг зүйтэй бөгөөд зохих газрын үлгэр туршлагыг авах тусгай мэргэжилтэн нарыг олж оролцуулан урьдаар зохих төлөвлөгөө боловсруулах ба гүйцэтгэлийг мэргэжилтэн нөхөр Симуковт, Тасгийн эрхлэгч Цэвэл нарт даалгасан байна (ШУХ. х.23, д.1, хн. 539, 1-2, МУУТА).

Тасгийн эрхлэгчээр ажиллаж байсан Я.Цэвэл шинжлэх ухааны байгууллагын тухай нэгэн өгүүлэлдээ “Сүм хийдүүдэд жинхэнэ гар хүрч халдах тэр үеэр уг сүм хийдэд байсан бурхан, ном судар болон түүх дурсгал, соёл урлагийн зүйлд холбогдолтой сонин ховор юмсыг улсын хамгаалалд тусгайлан авч хадгалах тухай саналыг тавихын хамт биечлэн явж танилцах, авах зүйлээ тусгайлан ялгахын тул хүрээлэнгийн дарга Дэндэвийн тушаалаар Цэвэл, Дэндэв, **Төмөр-Очир** нарын зэрэг хүмүүс томилогдож, тэр үед Засгийн газраас Шашны захиргааны дэргэд суулгаж байсан төлөөлөгч Лувсанжамьяангийн хамт явж Хүрээ, Гандангийн олонх аймаг, Дацангийн сүм дуган, Дамбадаржаа, Манзуширын хийд дахь түүх дурсгал, соёл урлагийн зүйлд холбогдох сонин чухал юм өдий төдийг нүд үзэж, тус тусын газарт нь тусгайлан ялгаж тавиад тэдгээр ялгасан юмсыг хүрээлэнгийн мэдэлд шилжүүлэх зөвшөөрөл шийдвэр авахаар Дотоод яамны Шашин, лам нарын хэрэг эрхлэх хэлтэс ба онцгой комисст тавьсан билээ” (Я.Цэвэл, 1971) хэмээн сүм хийдийн талаар явуулж байсан судалгаа, үйл ажиллагааны талаар өгүүлжээ.

Гүн ухааны тасаг: 1930 оны 09 дүгээр сард Намын Төв Хорооны дэргэд Маркс, Лениний суртал номлох зүйлийг орчуулах коллеги байгуулж, түүний гишүүдээр Дугаржав, Цэндсүрэн, Дашням, Магсар, Б.Банзрагч, Элдэв-Очир нарыг ажиллуулжээ. Тус коллегид Шинжлэх ухааны хүрээлэнгээс ч зарим хүн багтсан байгаа нь энэ чиглэлийн сурталчилгаа, судалгааг эрхлэхэд туршлагажиж цаашид судалгааны эл чиглэлийг бэхжүүлэхэд анхаарч байсныг харуулж байна (Д.Дашжамц 2015). 1931 онд Шинжлэх ухааны хүрээлэнд **Лекцийн товчоог** (хожмын Эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэг) байгуулсан бөгөөд сурталчилгааны сэдэвт **“Марксизм-ленинизмын үндсийг тайлбарлан нэвтрүүлэх”, “Шашны эсрэг суртлыг нэвтрүүлэх”** гэсэн сэдвүүд багтсан нь тасгийн үйл ажиллагаанд шууд холбогдож байжээ.

1938 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Шинжлэх ухааны хүрээлэнгийн Тэргүүлэгчдийн хурлаар Б.Банзрагчаас эрдэм шинжилгээний ажилтнуудын мэргэжил, сурлагыг дээшлүүлэх талаар гадаад хэлний дугуйлан ба улс төрийн лекцүүдийг явуулах тухай төлөвлөгөөг хэлэлцэн улс төрийн боловсролын тусгай дугуйланг ба тусгай лекцүүдийг явуулах зүйтэй хэмээн уг төлөвлөгөөг сайшаан баталжээ (ШУХ. х.23, д.1, хн. 482, 25, МУУТА). Мөн 1939 оны шинэ хүчнийг

бэлтгэх, ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх тухай төлөвлөгөөнд Маркс, Энгельс, Ленин, Сталины номлолуудыг судлах асуудлыг тусгасан байна (ШУХ. х.23, д.1, хн. 583, 28, МУУТА). Ийнхүү эрдэм шинжилгээний ажилтнууд нийгмийн шинжлэх ухаан, гүн ухааны онолын мэдлэгээ гүнзгийрүүлэх шаардлагыг тусган Шинжлэх ухааны хүрээлэнгээс марксизм ленинизмийн тухай ном бүтээлийг орчуулах, судлахад илүү анхаарах болжээ.

Шашныг судлах тасгийг 1939 онд Гүн ухааны тасаг болгон тасгаас хийсэн ажлын тайлангийн эхэнд: “Тус тасаг эхэндээ Төвөдийг ба дараа нь Шашин, лам нарын явдлыг судлах тасаг болж нэг жил ажиллан ирсний дээр 1939 оны 04 дүгээр сард мөнхүү тасгийн зөвлөгөөний хурлаар **Гүн ухааны тасаг** хэмээн нэрлэгдэж ирсэн юм. Ийнхүү тус тасгийг Гүн ухааны тасаг болгосон авч голлож эрхлэх ажил үүрэг нь Маркс, Энгельс, Ленин, Сталины материалист философийн зүйлүүдийг юуны урьд монгол хэлээр орчуулан дэлгэрүүлж, буддизмын харгис философийн эсрэг бэхжүүлэн ард түмнийг хүмүүжүүлэх явдалд хүчтэй оролцохыг мөнхүү зөвлөгөөний хурлын нөхөд үүрэг болгон даалгаж өгсөн амой” (ШУХ. х.23, д.1, хн. 583, 17, МУУТА) хэмээжээ. Үүнээс үзвэл, тасгийн зөвлөгөөний хурлаар тасгийн нэр өөрчлөхийг шийдсэн байна.


1939 онд тус хүрээлэнгийн **Гүн ухааны тасгийн эрхлэгч нь Наваан** байсан бөгөөд, тасгийн зөвлөлийн дарга нь Л.Дэндэв, гишүүд Б.Наваан, Б.Банзрагч, Баярсайхан, Ж.Төмөрбаатар, Цэнд, Цэгмэд, Ц.Цэдэнжав, Симуков, Дашдэндэв нар байжээ (ШУХ. х.23, д.1, хн. 581, МУУТА).

Шинжлэх ухааны хүрээлэнгийн Гүн ухааны тасгийн нэршлийн тухайд 1939 онд Зөвлөлтийн эрдэмтэн Марксизм, ленинизм хэмээхийг зөвлөжээ. Энэ талаар нэгэн баримтад “*БНМАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэнгийн Гүн ухааны тасгийн ажилд зөвлөх Поздняков (М.З. эрдэмтэн зөвлөх Д.Поздняков 1940 онд тус хүрээлэнгийн 20 жинхэнэ гишүүнд сонгогдож байсан) лугаа харилцан түүнээс өгсөн зөвлөгөөг тусгасан нь: 1/ Гүн ухааны түүхийн хэмээх нэр марксизм ба ленинизмийн түүх хэмээвээс юм. 2/ Одоо даруй хийх ажил: Тасгаа байрлуулах ба хэнд ч хэрхэн мэдэгдэхээр байгуулах, 3/ Орон сууц*” (ШУХ. х.23, д.1, хн. 663, МУУТА) гэж тэмдэглэсэн ба үүнээс хойших баримтуудад “Марксизм, ленинизмийн тасаг” хэмээх болсон нь ажиглагдаж байна. Энэ үед философийг гүн ухаан хэмээн орчуулж хэвшсэн, харин “мораль”-ийг орчуулахгүй хэрэглэх нь нэлээд байжээ.

Тус тасгийн 1939 оны гүйцэтгэх ажлын төлөвлөгөө нь үндсэндээ таван зүйлд хураангуйлагдаж, хэрхэн биелүүлснийг эрхлэгч Навааны бичсэн тайлангаас дурдвас: 1. Маркс, Энгельсийн материалист философийн зүйлүүдийг төлөвлөгөөтэйгөөр орчуулан хэвлэн нийтлэх ажил байсан бөгөөд үүнд: 1) В.И.Ленин, Карл Маркс, 2) марксизмын тухай ба үндэс, 3) Карл Маркс, Фейербахын тухай сэдвүүд, 4) С.Калининий Марксын философийн урьд гарсан тухай, 5) Э.Шиткисий “Марксын диалектик материализмын үндсэн зарим тэмдгийн тухай”, 6) Пованер “Марксын философийн материализм”, 7) Ф.Горохов “Нийгмийн ахуй ба нийгмийн мораль”, 8) Ф.Энгельс “Людвиг Фейербах”, 9) Максимов “Материализмын эмпириокритизм болбоос байгалийн ололтуудыг материализм ёсоор зассан дүн юм, 10) Ф.Энгельс “Утопиос шинжлэх ухаанд дэвшсэн социализм”, 11) Материализм ба идеализм, эдгээрийг орчуулж сийрүүлэн бэлтгэсэн байна. Үүнээс заримыг нь хөх дэвтэр

болгон хэвлэн гаргах ба заримыг нь сэтгүүлд тавих зэргээр гүйцэтгэх ёстой байсан авч үүний дотроос 2 ба 3 дахь зүйлийг хэвлэн гаргасан ба 1 ба 4 дэх зүйлийг хянан редакторлаж хэвлэхэд бэлтгэсэн (ШУХ. х.23, д.1, хн. 583, 18, МУУТА) гэж өгүүлээд 2-рт Шинжлэх ухааны хялбаршуулсан жижиг зохиол орчуулж хэвлэх, 3-рт Шашны эсэргүүцэх сурах бичиг орчуулж хэвлэх, 4-рт Буддын шашны номлолын хуурмагийг илэрхийлсэн зохиолуудыг хэвлэх, 5-рт Шашныг эсэргүүцэх музей байгуулахад оролцох зэргээр тусгасан боловч уг музейн төлөвлөгөө зэрэг нь гараагүй гэхчлэн таван зүйлээр дүгнэн тайлбарлаж тайлагнажээ.

Зураг 2. Гүн ухааны тасгийн 1939 оны ажлын төлөвлөгөө




“Шинжлэх ухааны хүрээлэнгийн Гүн ухааны тасгаас 1940 онд гүйцэтгэх ажлын календарьчилсан төлөвлөгөөг тасгийн эрхлэгч Б.Наваан боловсруулжээ. Үүнд:

1. Лениний зохиол, Карл Маркс хэмээх сэдвээр ном хийж, улс төрийн хяналтаар оруулж хэвлэх /Наваан/
2. Ф.Энгельсийн зохиол “Людвиг Фейербах” хэмээх дэвтрийн орчуулга хийж хэвлэлд шилжүүлэх /Наваан ба судлагч/
3. Ф.Энгельсийн “Утопиос шинжлэх ухаанд дэвшсэн социализм” хэмээх зохиолын орчуулга хийж хэвлэлд өгнө /Тасгаас/
4. И.Сталин “Үндэсний асуудал” хэмээх зохиолын орчуулга /Тасгаас/
5. “Шашныг эсэргүүцэх сурах бичиг” хэмээх зохиолыг орчуулж хянан тунгааж хэвлэлд бэлтгэх /Наваан/
6. “Лениний философи” зохиолыг орчуулж хянан тунгааж хэвлэлд шилжүүлэх /Тасгаас/
7. Түүхийн тасагтай хамтарч МАН-ын хувьсгалт намын түүхийг боловсруулан зохиомуй /Наваан, Нацагдорж нараас төв комисстой хамт гүйцэтгэх/

8. “Большевик ба марксизмын гүн ухаан” хэмээх сэтгүүлээс гүн ухааны 10 жижиг зохиол сонгон орчуулах хянан засварлаж хэвлүүлэх /Наваан ба Симуков/
9. Маркс, Энгельс, Ленин нарын төрсөн хийгээд нас нөгчсөн өдрүүд ба Сталины төрсөн өдрийг тохиолдуулан үзэсгэлэн, лекц зохион байгуулах /гэрэл зураг, номын сан, Түүхийн тасаг хамтрах/” (ШУХ. х.23, д.1, хн. 583, 9-16, МУУТА) зэрэг нийт 12 ажил хийхээр төлөвлөжээ. Энд шашныг эсэргүүцэх талаар сурах бичиг орчуулах ажлыг багтаасан байна.

Зураг 3. Гүн ухааны тасгаас 1938 онд гүйцэтгэсэн ажлын тайлан



1940 онд Марксизм, ленинизмийн тасаг хэмээгдэх болсон байна. Мөн 1940 оноос Шинжлэх ухааны хүрээлэнгийн Түүхийн кабинетын ажлын төлөвлөгөөнд МАХН-ын түүх, Маркс, Энгельс, Лениний зохиол бүтээлүүдийг орчуулах, хэвлэх ажлууд түлхүү тусгагдах болжээ. Иймд 1941 онд марксизм-ленинизмийг сурталчлах ажил нь хариуцах хүнгүйгээс хоцрогдож буй, нөгөө талаар ажил төрлийн талаар Түүхийн кабинетад хамаарагдах тул Шинжлэх ухааны хүрээлэнгийн дарга Дүгэрсүрэнгийн 106 тоот тушаалаар Түүхийн кабинетыг өргөтгөн секц болгож даргаар Ш.Нацагдоржийг томилсон. **Түүх, марксизм, ленинизмийн кабинетын** төлөвлөсөн ажлын хүрээнд 1943 онд И.В.Сталины “Ленинизмийн асуудлууд” зохиол, “**Гүн ухааны толь бичиг**”-ийг орчуулж гүйцэтгэсэн, “Марксист философи материализм”, “Хүний гарал”, “Шашны гарал”, “Сүнс бий юу” зэрэг лекцийг боловсруулсан байна. Тус кабинетын дотор Намын түүхийн секторын даргаар Ж.Төмөрбаатар ажиллаж, “Эв хамт намын тунхаг бол ялж дийлсээр ирсэн коммунизмын программ мөн”, “Ангийн тэмцлийн стратеги ба тактикийн тухай марксизмын сургаал” зэрэг олон өгүүллийг “Шинжлэх ухаан” (1948, №01) сэтгүүлд бичиж байв (Б.Пунсалдулам, С.Амарбаяр, Ц.Энхжаргал 2021).

Эл бүхий суурин дээр 1941 онд Монгол Улсын түүхэн дэх анхны дээд сургууль болох Намын шинэ хүчний Дээд сургууль байгуулагдаж, түүний сонсогчдод байгаль, нийгэм, улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн ухааны гол салбаруудаар, тэдгээрийн дотор марксист философийн үндсээр хичээл заах, түүний гол хэлбэр болгож лекц уншуулах ажил тулгамдан тавигдсан байна. Д.Төмөр-Очир НШХДС-д 1941-1942 оны хичээлийн жилийн хоёр дахь хагас, 1942-1943 оны хичээлийн жилийн туршид буюу 1942 оноос эхэлж философийн хичээл зааж, уншсан лекцүүдийн түрүүч нь 1943 онд хэвлэгдсэн (Жамбал А, 2021). Түүний 1945-1946 онд бичсэн диалектик материализмын түүхийн 15 дэвтэр бүхий товхимол монгол бичгээр хэвлэгдсэн нь философийн түүхийг танин мэдэхэд чухал хувь нэмрийг оруулжээ.

Мөн 1921-1945 онд Шинжлэх ухааны хүрээлэнгээс Маркс, Энгельс, Ленин, Сталины алдарт зохиолуудаас арваад зохиолыг монголчилж хэвлэсэн байна... Шашны гарал, огторгуйн уудам дахь дэлхий, байгалийн аймшигт хүчин, огторгуйн үзэгдлийг шинжлэх ухаан ба шашнаас хэрхэн тайлбарлах гэх мэтийн хэд хэдэн дэвтрийг хэвлэжээ. Энэ бол эрдэм шинжилгээний зохиол бөгөөд олон нийтгээс шашны мэхлэлийг таньж түүнийг эсэргүүцэх явдалд тусламж болох чухал зохиолууд (Я.Цэвэл 1946) байжээ.

Марксист философийн ном товхимол орчуулах, өгүүлэл, нийтлэл хэвлэх ажил үргэлжилсээр 1948-1949 онд “Шинжлэх ухаан” сэтгүүлд Ж.Төмөрбаатар “Ангийн тэмцлийн стратеги ба тактикийн тухай марксизмын сургаал”, Б.Цэдэн “Хөрөнгөт бус хөгжлийн замд шилжин орох бэлтгэл үе дэх ангийн тэмцэл” гэсэн гурван цуврал өгүүлэл, Ц.Төртогтох “Марксизм ба үндэсний асуудал”, 1951 онд Н.Жагварал “Суурь ба давхаргын тухай”, 1953 онд Д.Төмөр-Очир “Хөрөнгөтний бус хөгжлийн замын тухай марксист-ленинист сургаал”, Ц.Балхаажав “Марксизм ленинизм бол монголын ард түмний ялалтын туг мөн”, Н.Жагварал “Марксизм-ленинизмын онолын суут мэргэнээр хөгжүүлсэн нь” сэдэвт өгүүлэл, нийтлэл хэвлэгдсэн байна (ШУА, 1941-1955 он хүртэл «Шинжлэх ухаан» сэтгүүлд хэвлэсэн зүйлүүдийн товьёг 1965).

Шинжлэх ухааны хүрээлэнгийн захирал Н.Жагварал 1954 оны ажлын тайландаа зарим кабинетын ажил хийж байгаа ажилтайгаа зөрдөг, Түүх болон марксизм, ленинизмын кабинет байсан боловч одоо марксизм ленинизмын зохиолуудыг орчуулах ажлыг тусгай редакцын газар эрхлэн хийх болсон, иймд түүхийн судалгааны үндсэн сэдэв эх орны түүхийн зангилаа асуудлаар судалгаа хийх гэж томьёолоод, Нийгмийн ухааны секторт Түүх, археологи, Хэл утга зохиол, Нэр томьёоны комисс, Эдийн засгийн тасаг байгуулах нь зүйтэй (Б.Пунсалдулам, С.Амарбаяр, Ц.Энхжаргал 2021) гэсэн саналыг дэвшүүлжээ. Улмаар 1955 онд Намын Түүхийн Институт байгуулагдаж, тэнд Шинжлэх ухааны хүрээлэнгийн Түүхийн кабинетаас намын түүх, марксизм-ленинизмын судалгаа, шинжилгээний ажил шилжсэн нь цаашид философийн судалгааг мэргэжлийн удирдлагаар хангах чухал ач холбогдолтой шийдэл байсан гэж дүгнэж болохоор юм.

IV. Хэлэлцүүлэг

Шинжлэх ухааны хүрээлэнгийн Шашныг судлах болон Гүн ухааны тасгийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, Шашныг судлах тасгийг нэрт эрдэмтэн Я.Цэвэл удирдаж байсныг архивын баримтад тулгуурлан энэхүү өгүүлэлд тодруулав.

Түүнийг ажиллаж байх үед төр засгаас шашны талаар онцлог бүхий бодлого баримталж байсан. Эрдэмтэн Я.Цэвэл ШУА-ийн 40 жилийн ойд зориулан бичсэн “Миний дурдгатай” хэмээх дурсамждаа “Түүхийн тасаг 1924 онд бие даасан тасаг болсон бөгөөд түүх, цааз хууль, хэв суртал, гүн ухаанд холбогдох ажлыг эрхлэн гүйцэтгэж байсан. Хожимхон үед энэ тасгаас Цааз хууль ба хэв суртлыг шинжлэх тасаг, Түвэд ийн соёл боловсролыг судлах тасаг (**Шажны явдлыг судлах тасаг, Гүн ухааны тасаг** гэж нэрлэгдэж байсан зүйл бий) салж тусгай тасаг болж хэсэгхэн зуур явж байгаад Түүхийн тасагт (кабинет) нэгтгэгдсэн бөгөөд эдүгээ Түүхийн тасаг нь энэ завсар хөгжин хөгжсөөр Түүх судлах хүрээлэн болоод байна” (Я.Цэвэл 1961) хэмээжээ.

ШУА-ас эрхлэн хэвлүүлсэн “Монгол Улсын шинжлэх ухааны түүх” бүтээлийн хоёрдугаар ботид “1940 онд Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн жинхэнэ гишүүдэд 20 хүнийг Сайд нарын зөвлөлөөс сонгон батлахад Марксизм, ленинизмийн тасгийн дарга, эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Банзрагч (1937 онд хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1941 онд ахлах ажилтан) сонгогджээ” (Б.Пунсалдулам, С.Амарбаяр, Ц.Энхжаргал 2021, 33) гэж бичсэн нь тасгийн нэрийн өөрчлөлтийг тодруулах нэгэн зүйл мөн. Тэгэхээр Гүн ухааны тасгийн нэрийг Марксизм, ленинизмийн тасаг хэмээн өөрчилж, 1939 онд тасгийн эрхлэгч Б.Наваан, 1940 онд Б.Банзрагч болжээ гэж үзэхэд хүргэж буй. Энэ өгүүлэлд тасгийн ажлын төлөвлөгөө, тайлан, Шашныг судлах тасгийн анхдугаар зөвлөгөөнд оролцогчдын санал шүүмжлэл зэргийг архивын баримтаас нягтлан сийрүүлж ашиглав.

V. Дүгнэлт

Шинжлэх ухааны хүрээлэнд Шашныг судлах болон Гүн ухааны тасаг бий болсон түүхэн замналыг архивын болон бусад холбогдох хэрэглэгдэхүүнээр мөшгөн судлах нь шинжлэх ухааны салбарын түүх судлалд чухал ач холбогдолтой болно.

Тухайн үед Шинжлэх ухааны хүрээлэнгээс шашны талаарх бодлогын шинжлэх ухааны үндэслэлийн талаар санаа бодлоо илэрхийлэхийн зэрэгцээ хүрээ хийдийн газруудад байгаа бурхан, ном судар, номын бар, бичиг данс, урлалын янз бүрийн сонин ховор юмс зэрэг соёлын өв болох зүйлийг үрэгдүүлэхгүй улсын хамгаалалтад авч судлан шинжлэх, хойч үедээ өвлүүлэхэд ихээхэн анхаарч байжээ. Энэ талаар Я.Цэвэл абугай 1961 оны дурсамждаа буддын шашны соёлын өвийг хамгаалах талаар хийж байсан ажлууд байсан ч, маш их зүйлийг хамгаалалтад авч чадаагүйд харамсан бичсэнээс харж болно. Тасгаас төр засгаас лам нар, шашны талаар явуулж буй бодлогод нийцэж ажиллах үүрэгтэй тул энэ хүрээнд анхдугаар зөвлөгөөн зохион байгуулах, Шашныг эсэргүүцэх музей байгуулах, сурах бичиг орчуулах зэрэг чухал ажлуудыг төлөвлөн ажиллажээ. Шашныг эсэргүүцэх музей байгуулах замаар Чойжин ламын сүм музей, Эрдэнэзуу хийд зэргийг хамгаалах арга ухаан ч боловсруулж байжээ. Шинжлэх ухааны хүрээлэнгийнхэн шашны соёл, мэдлэгийн өвийг хадгалж хамгаалах талаар Дотоод яамны Шашны асуудлыг эрхлэх газартай зөрчилдөж байсан нь ч баримтуудад дурдагдаж байна.

Эрдэмтэн Я.Цэвэл Шашныг судлах тасгийн эрхлэгчээр ажиллаж байсан тухай өөрийн намтартаа бичээгүй нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалсан эсвэл уг албанд их удаагүй учир ач холбогдол өгөөгүй юм болов уу гэсэн таамаглалыг төрүүлж байна. Харин шинжлэх ухааны салбарт ажиллаж байсан тухай дурсамжид Гүн ухааны тасгийг дурджээ.

1938 онд зохион байгуулагдсан Шинжлэх ухааны хүрээлэнгийн Шашныг судлах тасгийн анхдугаар зөвлөгөөн зохион байгуулагдаж, зөвлөгөөнд оролцогчдын саналаар шашинтай үзэл суртал, гүн ухааны үндэслэлтэй тайлбар ухуулгаар тэмцэхийн тулд судалгааны сэдэв, чиглэлээ тодотгох шаардлага үүссэн, түүнчлэн тасгийн нэрийг Гүн ухааны тасаг хэмээн өөрчилсөн байна. Энэ нь төр засгийн шашны талаарх бодлогын хүрээнд уялдуулсан үйл хэрэг байжээ. 1941 онд марксизм-лениннизмыг сурталчлах ажил нь Түүхийн кабинетад хамаарагдан тодорхой ажлууд хийгдэж байсан. Түүхийн кабинетын эрхэлж байсан намын түүх, марксизм-лениннизмын судалгаа, шинжилгээний ажил нь 1955 онд Намын Түүхийн институтэд шилжсэн нь философич, дэд эрдэмтэн Д.Төмөр-Очир анхны захирлаар нь ажиллах болсон цаг үед тохиож байгаа юм.

Буддын шашин, гүн ухааны судар номыг бүртгэн цуглуулах ажил, марксист философи, буддын шашны түүх, шашны мөн чанарыг танин мэдэх чиглэлээр ном, товхимол бичих, орчуулах, лекц таниулга хийх зэрэг эрдэм судлалын нэгжийг Судар бичгийн хүрээлэнд байгуулж байсан бол эдүгээ 50 гаруй жилийн түүхтэй ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Философи, Шашин судлалын салбар үйл ажиллагаа явуулж байна. Цаашид манай улсын философи, шашин судлалын мэргэжлийн сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын эхэн үеийн түүх, ажиллаж байсан хүмүүсийн намтрыг нарийвчлан судлах хэрэгтэй юм.

Ашигласан материал

- АЕГ. 2011. *Монгол Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхэтгэл (1921-1960)*. Ред. Өлзийбаатар Д. Улаанбаатар, 387.
- Батдорж Ч, Хишиг Н, Чулуун С. 2021. *Монгол Улсын шинжлэх ухааны түүх. I боть*. Улаанбаатар, 66-67, 389.
- Дашжамц Д. 2015. Монголд марксизм дэлгэрч эхэлсэн нь, түүний онцлог. *Монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн асуудал*. Эмх. Жамбал А, Золзаяа М. Улаанбаатар, 140.
- Жамбал А. 2021. Монголын философийн сэтгэлгээ, соён гэгээрүүлэлт ба гүн ухаантан Дарамын Төмөр-Очир (1940-өөд оноос 1960-аад оны эхэн). *Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Дарамын Төмөр-Очир*. Улаанбаатар, 17.
- Пунсалдулам Б, Амарбаяр С, Энхжаргал Ц. 2021. *Монгол Улсын шинжлэх ухааны түүх. (1930-1960)*. Vol. II. Улаанбаатар, 56.
- Цэвэл Я. 1961. Миний дуртатгал. *Шинжлэх Ухааны Академийн мэдээ*. ШУА-ийн хэвлэл, 91.
- Цэвэл Я. 1971. Нэхэн дурсах дуртгал (Монголын шинжлэх ухааны байгууллагын тухай). *Шинжлэх ухаан, амьдрал* (№3; 4): 11-16; 13-20.
- Цэвэл Я. 1946. Монгол хэвлэлийн ажил ба БНМАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэнгээс хэвлэгдсэн утга зохиол. *Шинжлэх ухаан* 12-13: 90-97.
- Цэвэл Я. Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Ядамжав овогтой Цэвэл миний түүхт байдал 1974-1984. *Шагдарсүрэн Ц. 2020. Таргуд Ядамжавын Цэвэл*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Чулуунбаатар Г, Дашжамц Д. 2002. *Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн түүхийн хураангуй (1972-2002)*.

- Шагдарсүрэн Ц. 2020. *Таргуд Ядамжавын Цэвэл*. Улаанбаатар: Мөнхийн үсэг, 8.
- ШУА. 1965. 1941-1955 он хүртэл «Шинжлэх ухаан» сэтгүүлд хэвлэсэн зүйлүүдийн товъёг. Улаанбаатар.
- ШУА. 2011. *Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи*. Ред. Энхтүвшин Б. Улаанбаатар.
- МУУТА. ШУХ. х.23, д.1, хн. 482, 25.
- МУУТА. ШУХ. х.23, д.1, хн. 538, 6-7.
- МУУТА. ШУХ. х.23, д.1, хн. 539, 1-2.
- МУУТА. ШУХ. х.23, д.1, хн. 581.
- МУУТА. ШУХ. х.23, д.1, хн. 583, 17.
- МУУТА. ШУХ. х.23, д.1, хн. 583, 9-16.
- МУУТА. ШУХ. х.23, д.1, хн. 583, 28.
- МУУТА. ШУХ. х.23, д.1, хн. 583, 18.
- МУУТА. ШУХ. х.23, д.1, хн. 663.